

ТОВЧЛОЛ

“Туршилт судалгааны арга” эмхэтгэл ном нь эрдэм шинжилгээний туршилт судалгааг хэрхэн хэрэгжүүлэх талаар тайлбарласан сургалтын материал юм. Энэ номонд судалгааны ажлыг төлөвлөх ба хэрэгжүүлэх үе шатууд, бэлтгэл ажил, судалгааны зарчим, багж хэрэгсэл, аргачлал ба судалгааны ёс зүйг тусгасан. Мөн үр дүнгийн анализ хийх, эшлэл татах, үндэслэл ба хэлцэмж бичих, өгүүлэл/диссертаци бичих дараалал ба анхаарах зүйлсийн талаар өгүүлнэ. Энэ ном нь дээрхи мэргэжлийн магистрант, докторант ба бусад судлаачдад зориулсан сургалтын хэрэглэгдэхүүн болно.